



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/46/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Ахлах аудитор: Н.Болдбаатар
Утас: 70512127

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 10 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 10 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 11 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 12 |
| 4.1 Ерөнхий зүйл | 12 |
| 4.2 Материаллаг байдал | 13 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... | 13 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 13 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 14 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 14 |
| 5.1 Төлбөрийн акт | 14 |
| 5.2 Зөвлөмж | 15 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 15 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Х.ЦОГБААТАР ТАНАА

2023.08.24 № 71

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн системд бүрэн нэвтэрч, төрийн сангийн ажил гүйлгээг цахим болох бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 зорилт, 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 87.8 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>144,266,676.00</u> | <u>113,178,800.00</u> |
| 33 | АВЛАГА | 5,802,866.00 | - |
| 335 | Бусад авлага | 5,802,866.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,302,866.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 500,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 138,463,810.00 | 113,178,800.00 |
| 354 | Хангамжийн материал | 63,408,810.00 | 37,913,800.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,022,410.00 | 440,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,365,300.00 | 23,843,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,703,500.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 29,317,600.00 | 13,630,500.00 |
| 35600 | Мал амьтад | 75,055,000.00 | 75,265,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,659,341,127.73</u> | <u>1,864,692,485.80</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,659,341,127.73 | 1,864,692,485.80 |
| 392 | Биет хөрөнгө | 1,655,179,927.73 | 1,858,868,785.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,383,295,875.39 | 1,603,295,875.39 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (291,654,759.74) | (370,799,799.62) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 139,354,800.00 | 139,354,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (63,216,950.01) | (82,791,083.37) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 162,189,330.00 | 174,787,130.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (93,633,049.53) | (115,310,902.70) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 50,892,330.00 | 51,372,330.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,132,490.24) | (37,300,910.46) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 599,581,616.00 | 737,854,447.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (202,496,774.14) | (241,593,100.42) |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,161,200.00 | 5,823,699.98 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 2,295,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (300,000.00) | (632,500.02) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,161,200.00 | 4,161,200.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,803,607,803.73</u> | <u>1,977,871,285.80</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>5,302,866.00</u> | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 5,302,866.00 | - |
| 413 | Өглөг | 5,302,866.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 5,302,866.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 5,302,866.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,798,304,937.73</u> | <u>1,977,871,285.80</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,798,304,937.73 | 1,977,871,285.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 388,407,412.66 | 388,407,412.66 |
| 51101 | Өмч: - төрийн | 388,407,412.66 | 388,407,412.66 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,274,919,491.56 | 1,454,485,839.63 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,274,919,491.56 | 1,274,919,491.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 179,566,348.07 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 134,978,033.51 | 134,978,033.51 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,803,607,803.73</u> | <u>1,977,871,285.80</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 273,272,237.00 | 549,789,338.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 9,620,000.00 | 2,040,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 9,620,000.00 | 2,040,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,620,000.00 | 2,040,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 500,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,620,000.00 | 1,540,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 263,652,237.00 | 547,749,338.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 37,512,537.00 | 53,564,238.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,895,100.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,131,167.00 | 20,224,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 837,470.00 | 9,253,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,648,800.00 | 24,086,138.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 226,139,700.00 | 494,185,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 226,139,700.00 | 494,185,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 294,882,552.94 | 728,495,820.93 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 294,882,552.94 | 728,495,820.93 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 290,730,386.94 | 697,562,983.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 127,644,142.99 | 258,373,788.45 |
| 210101 | Үндсэн цалин | 84,337,157.37 | 192,075,486.85 |
| 210102 | Нэмэгдэл | 29,320,975.43 | 43,361,774.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 13,644,305.95 |
| 210104 | Урамшуулал | 3,689,638.15 | 9,292,221.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 10,296,372.04 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,588,334.89 | 31,547,223.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,728,906.10 | 21,699,278.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,214,877.66 | 2,518,973.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 971,902.16 | 2,015,179.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 242,893.63 | 483,071.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,429,755.34 | 4,830,719.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,926,468.00 | 20,805,625.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,134,400.00 | 8,816,803.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,502,068.00 | 10,314,822.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,290,000.00 | 1,674,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,476,500.00 | 24,151,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 900,100.00 | 3,679,810.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,581,600.00 | 16,412,890.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 994,800.00 | 2,550,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,175,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 333,900.00 |
| 2105 | Нормативт зардал | - | 245,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 245,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 44,000.00 | 3,482,395.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 44,000.00 | 679,495.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 2,802,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,700,000.00 | 5,763,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,700,000.00 | 5,763,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,462,641.00 | 8,176,939.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,409,680.00 | 6,548,830.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 32,961.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 692,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 117,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 48,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 81,000.00 |

| | | | |
|-------------|--|------------------------|-------------------------|
| 210807 | Газрын төлбөр | 20,000.00 | 37,409.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 110,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 109,888,300.06 | 345,017,312.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,387,997.00 | 176,812,540.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 530,100.00 | 210,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,970,203.06 | 167,994,272.93 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,152,166.00 | 30,932,837.14 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,152,166.00 | 21,508,554.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 3,852,166.00 | 8,103,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 12,271,654.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 1,133,500.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 9,424,283.14 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,424,283.14 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (21,610,315.94) | (178,706,482.93) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (21,610,315.94) | (178,706,482.93) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 587,163,147.00 | 553,552,204.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 5,802,866.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 5,802,866.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 5,802,866.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 500,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 5,302,866.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 587,163,147.00 | 547,749,338.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 89,566,347.00 | 53,564,238.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,895,100.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,066,377.00 | 20,224,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 40,575,670.00 | 9,253,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,029,200.00 | 24,086,138.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 497,596,800.00 | 494,185,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 497,596,800.00 | 494,185,100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 580,248,147.00 | 538,479,404.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 580,248,147.00 | 538,479,404.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 522,990,204.96 | 507,401,566.86 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 249,710,283.99 | 258,029,288.45 |
| 210101 | Үндсэн цалин | 176,306,624.98 | 191,730,986.85 |
| 210102 | Нэмэгдэл | 53,895,109.81 | 43,361,774.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,183,378.41 | 13,644,305.95 |
| 210104 | Урамшуулал | - | 9,292,221.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 12,325,170.79 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,422,657.97 | 31,547,223.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,816,245.87 | 21,699,278.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,401,623.47 | 2,518,973.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,921,298.77 | 2,015,179.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 480,242.78 | 483,071.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,803,247.08 | 4,830,719.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 32,792,813.00 | 22,986,762.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,729,353.00 | 8,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,839,526.00 | 12,812,762.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,223,934.00 | 1,674,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,882,216.00 | 19,693,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,859,396.00 | 2,258,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,220,630.00 | 13,210,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,802,190.00 | 2,550,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,175,000.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------|------------------------|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 500,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 148,800.00 | 125,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 148,800.00 | 125,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,707,000.00 | 4,209,895.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 207,000.00 | 1,009,495.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 210,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 2,990,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,196,450.00 | 9,204,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,196,450.00 | 9,204,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,104,300.00 | 8,817,209.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,432,400.00 | 7,189,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 269,300.00 | 225,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 235,200.00 | 726,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 101,400.00 | 84,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 46,000.00 | 48,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 396,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 20,000.00 | 37,409.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 110,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 163,025,684.00 | 152,788,589.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 162,224,684.00 | 152,288,589.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 801,000.00 | 500,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 57,257,942.04 | 31,077,837.14 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20,984,307.00 | 21,653,554.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 8,184,307.00 | 8,193,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 12,291,654.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,800,000.00 | 1,168,500.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 36,273,635.04 | 9,424,283.14 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,273,635.04 | 9,424,283.14 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 6,915,000.00 | 15,072,800.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 6,915,000.00 | 15,072,800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6,915,000.00 | 15,072,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6,915,000.00 | 15,072,800.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 6,915,000.00 | 15,072,800.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (6,915,000.00) | (15,072,800.00) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------------|--|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 388,407,412.26 | 134,978,033.51 | 1,107,919,880.59 | 1,631,305,326.36 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 388,407,412.26 | 134,978,033.51 | 1,107,919,880.59 | 1,631,305,326.36 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 166,999,610.97 | 166,999,610.97 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 388,407,412.26 | 134,978,033.51 | 1,274,919,491.56 | 1,798,304,937.33 |
| D01 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 388,407,412.26 | 134,978,033.51 | 1,274,919,491.56 | 1,798,304,937.33 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 388,407,412.26 | 134,978,033.51 | 1,274,919,491.56 | 1,798,304,937.33 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 179,566,348.07 | 179,566,348.07 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 388,407,412.26 | 134,978,033.51 | 1,454,485,839.63 | 1,977,871,285.40 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 524,201,000.00 | 487,318,028.86 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 524,201,000.00 | 487,318,028.86 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 502,016,000.00 | 465,664,474.86 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 288,832,000.00 | 258,029,288.45 |
| 210101 | Үндсэн цалин | 213,297,600.00 | 191,730,986.85 |
| 210102 | Нэмэгдэл | 47,876,200.00 | 43,361,774.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,707,600.00 | 13,644,305.95 |
| 210104 | Урамшуулал | 11,950,600.00 | 9,292,221.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 36,103,900.00 | 31,547,223.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,550,700.00 | 21,699,278.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,888,300.00 | 2,518,973.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,310,600.00 | 2,015,179.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 577,700.00 | 483,071.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,776,600.00 | 4,830,719.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,100,000.00 | 21,486,762.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,500,000.00 | 8,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,000,000.00 | 12,812,762.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 174,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,435,100.00 | 18,432,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,260,100.00 | 2,258,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,000,000.00 | 11,999,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,175,000.00 | 1,175,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 500,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 125,000.00 | 125,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 125,000.00 | 125,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,850,000.00 | 12,787,795.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,600,000.00 | 9,587,395.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 250,000.00 | 210,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,990,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,100,000.00 | 5,100,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,100,000.00 | 5,100,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,970,000.00 | 10,812,209.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,189,100.00 | 7,189,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 225,000.00 | 225,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 765,000.00 | 726,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,000.00 | 84,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 95,000.00 | 48,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,391,000.00 | 2,391,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 110,000.00 | 37,409.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 110,900.00 | 110,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 107,500,000.00 | 107,344,197.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 107,000,000.00 | 106,844,197.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 22,185,000.00 | 21,653,554.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22,185,000.00 | 21,653,554.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 8,193,400.00 | 8,193,400.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,341,600.00 | 12,291,654.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,650,000.00 | 1,168,500.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 523,017,700.00 | 494,685,100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 522,517,700.00 | 494,185,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 522,517,700.00 | 494,185,100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 500,000.00 | 500,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 500,000.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын сумын Засаг даргын Тамгын газар нь “Засаг даргыг цаг үеэ олсон бүх талын зөвлөгөө, мэдээллээр хангах, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сум орон нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааны үр ашигтай, тасралтгүй жигд хэвийн нөхцөлийг баталгаатай хангах замаар улс төрийн аливаа нөлөөлөлд авталгүй иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд оршино” гэсэн зорилгын хүрээнд 7 зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 174,263.5 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 5,802.9 | - | -5,802.9 |
| Бараа материал | 138,463.8 | 113,178.8 | -25,285.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,659,341.1 | 1,864,692.5 | 205,351.4 |
| Нийт хөрөнгө | 1,803,607.8 | 1,977,871.3 | 174,263.5 |
| Өр төлбөр | 5,302.9 | - | -5,302.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,798,307.9 | 1,977,871.3 | 179,563.3 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,803,607.8 | 1,977,871.3 | 174,263.5 |

- Үндсэн хөрөнгө данс 1,864,692.5 мянган төгрөг болж 205,351.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр 15,072.8 мянга, хандиваар 220,000.0 мянга, үнэ төлбөргүй 138,272.8 мянга нийт 373,345.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 174,263.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 429,070.1 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 524,201.0 мянган төгрөг батлагдсан байна..

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхэд 524,201.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 487,318.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр орон нутгаас 494,185.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 6,867.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 487,318.0 мянган төгрөг буюу 98.6 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|---|------------|------------|-----------|---------|
| 1 | 80101-Үндсэн үйл ажиллагаа | 335,848.40 | 309,260.30 | 26,588.10 | 92% |
| 3 | 80106-Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 59,067.50 | 51,564.10 | 7,503.40 | 87.3% |
| 4 | 80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт | 8,193.40 | 8,193.40 | - | 100% |
| 5 | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 13,991.60 | 13,460.40 | 531.20 | 96.2% |

| | | | | | |
|------|--|-----------|-----------|----------|-------|
| 6 | 80918- Бусад | 55,324.10 | 55,324.10 | - | 100% |
| 6 | 81102-Орон нутгийн нөөц хөрөнгө | 40,000.00 | 39,923.80 | 76.20 | 99.8% |
| 7 | 81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал | 40,000.0 | 40,000.0 | - | 100% |
| 8 | 81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 9,400.00 | 8,772.33 | 627.67 | 93.3% |
| 9 | 81549-Ахмадын сан | 1,500.0 | 1,423.90 | 76.10 | 94.9% |
| 10 | 81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 13,500.0 | 12,981.60 | 518.40 | 96.2% |
| 11 | 82310-Гамшгаас сэргийлэх сургалт, суртчилгаа | 7,000.0 | 7,000.0 | - | 100% |
| | 83201-Анилагдаагүй бусад зориулалт арга хэмжээ | 5,000.0 | 4,996.40 | 3.60 | 99.9% |
| НИЙТ | | 524,201.0 | 487,318.0 | 36,883.0 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ,ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 20,224.5 мянга, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 9,253.6 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 24,086.1 мянга, нийт 59,367.1 мянган төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэлээр 58,871.1 мянган төгрөгийг зарцуулж 33,214.8 мянган төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл цэвэр бохир усны зардалд 1,500.0 мянга, хангамж бараа материалын зардалд 1,261.6 мянга, томилолтын зардал 4,104.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 49,948.3 мянга, бусад урсгал шилжүүлэгт 2,057.2 мянга нийт 58,871.1 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн № 03/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 715,763.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,736.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 9,710.2 мянга, бичиг хэрэг 1,357.9 мянга, тээвэр шатахуун 7,629.0 мянга, албан томилолтын зардал 7,504.0 мянга нийт 26,201.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Сангийн сайдын 2022 оны 06 сарын 02 өдрийн 120 дугаар тушаалаар албан томилолтын зардлын тариф шинэчлэн тогтоосон,
- Мөн тээвэр шатахууны зардал өмнөх оноос 50 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бүхий 10 зарлагын гүйлгээ, урсгал

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

санхүүжилтийн 24 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх албан шаардлага өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Дарьганга Засаг даргын Тамгын газарт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | /мянган төгрөгөөр/ Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------|----------------------------|----------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 450.0 | 1 | 450.0 | 100 |
| Албан шаардлага | 3 | 53,500.0 | 3 | 53,500.0 | 100 |
| Зөвлөмж | 2 | - | 2 | - | 100 |
| Нийт дүн | 6 | 53,950.0 | 6 | 53,950.0 | 100 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 180.9 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс, 180.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, шилэн дансны нэгдсэн сайтад мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлэх 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгож, төсвийг илүү зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.4 /сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно/, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6 /төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7 дахь заалттай нийцэхгүй байна.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин хөлс тогтоохтой холбоотой

Илрүүлэлт: Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Д.Оюун нь ТҮ-7 зэрэглэлээр цалинжиж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д "Нягтлан бодогчийн нэг орон тоотой аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа нягтлан бодогч, эсхүл гэрээт нягтлан бодогч нь нь ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэнэ" гэж мөн Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 7-р хавсралтад ерөнхий нягтлан бодогч ТҮ-8 зэрэглэлээр цалинжихаар заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодогчийн цалинг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоож, олгох

2. Албан томилолттой холбоотой

Илрүүлэлт: Албан томилолтыг удирдамж боловсруулаагүй төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон. Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.1 дэх /Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно./, 2.5 дахь "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална." заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Албан томилолтыг анхан шатны баримтыг бүрдүүлж, холбогдох журмын дагуу олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|--------------------|-------------|---------------|-----------------|---------|--------------------------------------|--|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|--|----------|--------------|----------|--------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
| Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгож | 1 | 180.9 | 1 | 180.9 | | | | | | | | |
| Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Д.Оюун нь ТҮ-7 зэрэглэлээр цалинжиж байна, | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Албан томилолтыг удирдамж боловсруулаагүй төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Дүн | 3 | 180.9 | 1 | 180.9 | - | - | 2 | - | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|----------|---------------|----------|-----------------|----------|----------|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын , урсгал санхүүжилтийн гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Дүн | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | 1 | - | - | - | - | - | 1 | - |